



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/662

Зуунмод

Өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1.4.8 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүний эрхийн өдрийг тохиолдуулан залуу эрдэмтэн, судлаач, багш, оюутнууд, төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх, хүний эрхийг дээдлэх, эрхээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинэ технологи, шинэлэг санааг нэвтрүүлэх, зорилгоор зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Тус арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2,430,000 (хоёр сая дөрвөн зуун гучин мянга) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т зөвшөөрсүгэй.

3.Хүний эрхийн батлагдсан удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР